



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 1/01

ӨВТ

Г Мод бэлтгэх зөвшөөрөл олгох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "м" заалт, 29.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2021 оны хэрэгзээний болон түлшний модны хуваарь батлах тухай" 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 3/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/15 дугаар тогтоолоор баталсан мод бэлтгэх хуваарийн дагуу Ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдэд мод бэлтгэх зөвшөөрөл олгосугай.
2. Мод бэлтгэх зөвшөөрөл авсан Ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулж, эрхийн бичиг олгож ажиллахыг сум дундын Ойн ангийн инженер (Д.Очирхуяг), Ойн ангийн техникч (А.Мягмардавга), Байгаль хамгаалагч (Н.Пүрэвтогтох, Ж.Батмөнх, Г.Цогтбаатар) нарт үүрэг болгосугай.
3. Тухайн жилийн хэрэглээний мод, түлээ бэлтгэх үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б. Янжиндулам)-д даалгасугай.
4. Ойн менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээг батлахыг сум дундын Ойн ангийн дарга (Ц. Очирсүрэн)-д зөвлөсүгэй.
5. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН